

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН 2025 ОНЫ  
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ  
ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2025.06.13

Даланзадгад сум

Засгийн газрын 2025 оны 43 тогтоолоор батлагдсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам"-ыг удирдлага болгон Хяналт шинжилгээ үнэлгээ мэдээллийн хэлтсийн ажлын төлөвлөгөөний дагуу Эрүүл мэндийн газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийлээ.

**НЭГ. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ГОЛ ЗОРИЛГО:**

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж, төлөвлөлт, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах, бодлогын баримт бичгийн үр дүнд хүрэх явцыг тогтмол хугацаанд ажиглан, зөв чиглүүлэхэд оршино.

**ХОЁР. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ:**

Засгийн газрын 2020 оны 217 тогтоолоор батлагдсан Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам, 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт Байгууллагын үйл ажиллагаа, Үр дүнг үнэлж дүгнэх журам "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг үндэслэн 2025 оны хагас жилийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээг 2025 оны 06 дүгээр сарын 9-13-ны өдрүүдэд зохион байгууллаа. Хяналт үнэлгээг эрүүл мэндийн газрын 4 хэлтэс, 1 төвийн ирүүлсэн тайланд нэгтгэн хийлээ.

**ГУРАВ. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ҮР ДҮН**

| Д/д | Зорилт арга хэмжээ     | Арга хэмжээний тоо | Дундаж хэрэгжилтийн хувь |
|-----|------------------------|--------------------|--------------------------|
| 1   | Зорилт арга хэмжээ 1.1 | 8                  | 80,7                     |
| 2   | Зорилт арга хэмжээ 1.2 | 21                 | 76,3                     |
| 3   | Зорилт арга хэмжээ 1.3 | 3                  | 93,3                     |
| 4   | Зорилт арга хэмжээ 2.1 | 7                  | 91,4                     |
| 5   | Зорилт арга хэмжээ 2.2 | 7                  | 85,7                     |
| 6   | Зорилт арга хэмжээ 2.3 | 5                  | 66,3                     |
| 7   | Зорилт арга хэмжээ 3.1 | 5                  | 79,4                     |
| 8   | Зорилт арга хэмжээ 4.1 | 11                 | 73,1                     |
| 9   | Зорилт арга хэмжээ 4.2 | 6                  | 100                      |
| 10  | Зорилт арга хэмжээ 4.3 | 5                  | 80                       |
| 11  | Зорилт арга хэмжээ 5.1 | 3                  | 76,6                     |
| 12  | Зорилт арга хэмжээ 5.2 | 3                  | 100                      |
| 13  | Зорилт арга хэмжээ 5.3 | 2                  | 83,3                     |
| 14  | Зорилт арга хэмжээ 5.4 | 5                  | 87                       |
| 15  | Зорилт арга хэмжээ 6.1 | 2                  | 100                      |
| 16  | Зорилт арга хэмжээ 6.2 | 11                 | 73,5                     |
| 17  | Зорилт арга хэмжээ 6.3 | 6                  | 81,3                     |
| 18  | Нийт                   | 110                | 83,9                     |

Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2025 онд хэрэгжүүлэхээр 17 зорилтын 110 арга хэмжээ төлөвлөж хэрэгжүүлэн тайлагнаснаас

- 85 хувь буюу “**бүрэн хангалттай**” – 63 арга хэмжээ
- 70-85 хүртэл хувь буюу “**хангалттай**” 16 арга хэмжээ
- 70 хүртэл хувь буюу “**хангалтгүй**” 25 арга хэмжээ

Хугацаа болоогүй 6 арга хэмжээ байна.

**“Хангалтгүй” цаашид эрчимжүүлэх шаардлагатай ажлууд**

**Арга хэмжээ 1.2.1.** Хүн амын дунд зонхилон тохиолдож буй өвчлөл тухайлбал, хөх, умайн хүзүүний хорт хавдар, чихрийн шижин, цусны даралт ихсэлт өвчний эрт илрүүлэх үзлэгт хамралтыг нэмэгдүүлэх. *Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэгт хамрагдвал зохих 27416 хүнээс 5911 буюу 21,6 хувь, чихрийн шижингийн эрт илрүүлэгт хамрагдвал зохих 19887 хүнээс 6076 буюу 30,6 хувь хүнийг, Хөхний өмөнгийн илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих нийт 12159 хүн хамрагдахаас 2992 буюу 24.6 хувь, Умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлэгт 5126 хүн хамрагдахаас 669 хүн буюу хамрагдалт 13.1 хувийг хамруулсан байна.*

**Арга хэмжээ 1.2.7.** Алслагдсан сумдад амны хөндийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг өргөжүүлэн үзлэг оношилгоо, эмчилгээний Явуулын баг ажиллуулан урьдчилан сэргийлэх, эмчлэн эрүүлжүүлэх арга хэмжээг зохион байгуулах

**Арга хэмжээ 1.2.10.** Салбарын хэмжээнд эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжих зорилтот арга хэмжээ (“Эрүүл монгол хүн”, “Халдварт өвчнөөс сэргийлэх хянах”, “Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх”, “Сэтгэцийн эрүүл мэнд” 2024-2027)-г үр дүнтэй батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх

**Арга хэмжээ 1.2.13.** Сэтгэцийн эрүүл мэнд, ялангуяа хүүхэд, өсвөр үеийнхэнд сэтгэлзүйн тусламж, үйлчилгээ үзүүлэх, сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, архи, тамхи, утаат болон электрон тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлийн талаарх мэдлэг олгох, хэрэглээг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах.

**Арга хэмжээ 1.2.19.** Эрэгтэйчүүдэд чиглэсэн нийгмийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх.

**Арга хэмжээ 1.2.20.** Олон нийтийн эрүүл мэндийн ажилтнуудыг сургаж чадавхжуулах, тэдгээрээр дамжуулан эрүүл мэндийн хүрч очих үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх,

**Арга хэмжээ 2.2.1.** “Эх хүүхдийн эрүүл мэнд” аймгийн хөтөлбөрийг тусгай төлөвлөгөөний хүрээнд үр дүнтэй хэрэгжүүлэх

**Арга хэмжээ 2.2.6.** Өрх, сумын эрүүл мэндийн төвд 9 сар, 18 сар, 36 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэг тогтмол зохион байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах, хөдөлгөөн засах тусламж, үйлчилгээг өргөжүүлж энэ чиглэлийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн байгууллагыг дэмжиж ажиллах */Хөгжлийн цогц үзлэгт хамрагдсан хүүхдийн хувь/*

**Арга хэмжээ 2.3.2** Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах, хөдөлгөөн засал тусламж, үйлчилгээг өргөжүүлж энэ чиглэлийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн байгууллагыг удирдлага арга зүйгээр хангах.

**Арга хэмжээ 4.2.2** Иргэдэд эрүүл мэндийн зуучлах үйлчилгээг үзүүлэх Өмнөговийн иргэдэд зөвлөн зуучлах төвийг Улаанбаатар хотод байгуулна.

**Арга хэмжээ 5.1.2.** Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 19.1.3 дахь заалтад Эрүүл мэндийн байгууллага нь онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллага гэж заасан тул эрүүл мэндийн мэдээллийн аюулгүй байдал, мэдээллийн системийн өдөр тутмын үйл ажиллагааг явуулахад шаардлагатай сервер, тоног төхөөрөмжөөр ханган байнгын хяналт тавьж ажиллана.

**Арга хэмжээ 5.1.3.** Кибер аюулгүй байдлын сургалтад Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагын мэдээллийн технологийн ажилтан, статистик мэдээллийн ажилчдыг улирал бүр хамруулна.

### **ДӨРӨВ. ДҮГНЭЛТ ЗӨВЛӨМЖ**

Эрүүл мэндийн газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө нийт 110 зорилтын ажил арга хэмжээ төлөвлөж биелэлтийг төлөвлөгөөний дагуу тайлагнасан.

Арга хэмжээг шалгуур үзүүлэлттэй уялдуулж тайлагнах, хүрсэн түвшин үр дүнг тодорхой, оновчтой тайлагнах.

Эрүүл элэг хөтөлбөр, Эх хүүхдийн эрүүл мэнд хөтөлбөрүүдийг 2025 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу ажлыг эрчимжүүлэх.

Хүн амын дундах Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэгт хамрагдвал зохих 27416 хүнээс 5911 буюу 21,6 хувь, чихрийн шижингийн эрт илрүүлэгт хамрагдвал зохих 19887 хүнээс 6076 буюу 30,6 хувь хүнийг, Хөхний өмөнгийн илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих нийт 12159 хүн хамрагдахаас 2992 буюу 24.6 хувь, Умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлэгт 5126 хүн хамрагдахаас 669 хүн буюу хамрагдалт 13.1 хувийг хамруулсан байгаа нь хангалтгүй байгаа тул эрчимжүүлэх.

Өрх, сумын эрүүл мэндийн төвд 9 сар, 18 сар, 36 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэг тогтмолжуулах, арга зүйгээр хангах,

Явуулын үзлэг болон анхан эрүүл мэндийн байгууллагууд харьяаллын бус хүн амд үзүүлсэн тусламж үйлчилгээний чанар, үр дүнг тооцож тайлагнах,

Нийт халдварт өвчнөөс БЗДХ-ын 261 тохиолдлын 58 буюу /22,2%/ -г өсвөр насны /14-19/ хүүхдүүд эзэлж цаашид өсөх хандлагатай байгааг анхаарч арга хэмжээ зохион байгуулж ажиллах.

Арга хэмжээг хэрэгжүүлэхэд зарцуулсан санхүүжилт, эх үүсвэрийн хамт тодорхой тайлагнаж байх.

-Эмгэг судлалын шинжилгээний хамралтын 45 хувь хангалтгүй байна.

ТАНИЛЦСАН:


ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА



Ц.ЖАВЗАНДУЛАМ

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ МЭДЭЭЛЛИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА



Б.ЦАГААНЦЭНД